БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 10 өдөр Дугаар А/394 Улаанбаатар хот

Дүүргийн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн
үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 07/01 дүгээр тогтоолоор батлагдсан "Дүүргийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3-2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад төрийн үйлчилгээг нэг дороос, түргэн шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх ажлыг зохион байгуулсугай.

2. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ОДОНТУЯА

D:\ 2018 он\Захирамжлалын ББ\Захирамж.docx

1160200045